# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**РД 4012534**

**Биелэлтийг тайлагнасан:**

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР П.БАТ-ОРШИХ

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ИНЖЕНЕР Ү.МАРТ

2025 ОН

**“УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ”ТӨХК** нь 2025 онд 7 төрлийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан төсөв болон үйл ажиллагааны зардлаар санхүүлэн хийж гүйцэтгэлээ. Төлөвлөгөө тус бүрээр тайлан гаргасан.

**Үүнд:**

## 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайлан

| Болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хугацаа | Зардал /төг/ | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** |
| **Тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч бохирдох, элэгдэх эвдрэх** | Үнс барих технологийг шинэчлэх | Агаарын чанар | 9 сард | 259,200,000 | 3 зуухны уутат фильтрийн 840ш уут бүрэн сольж, 22 квт-н 2 ширхэг компрессор суурилуулав. /Зураг 1/ |
| | Агаарын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах | | 3, 10 сард | 89,000 | Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвтэй гэрээ байгуулан агаарын шинжилгээг 2 удаа хийлгэсэн. /Зураг 2 / |
| **Хийн хаягдал, тоосжилт** | Орчны агаараас дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах | | | | |
| **Ус ашиглалт** | Усны төлбөр төлөх | Усны чанар | Сар бүр | Тоолуурын заалтаар | “Чандмань Увс”ХХК-тай гэрээ байгуулан ажилласан. /Зураг 3/ |
| | Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журмыг мөрдөж тус журмын дагуу тоолуур суурилуулах. Цэвэр, | Усны нөөц хэмнэх | - | | Суурилагдсан тоолуур баталгаажуулсан. Бохир усыг хэрэглэсэн цэвэр усны 20%-иар тооцдог. /Зураг 4/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бохир усны тоолуур суурилуулж баталгаажуулах. | | | | |
| **Тоосжилт, Хөрсний элэгдэл, эвдрэл** | Сул чөлөөтэй талбайг тарималжуулж, ногоон байгууламж байгуулах | Агаарын чанарт хөрс, ургамлан нөмрөг | 5, 6, 10 сард | 4,500,000 | 4-5 нэр төрлийн 403ш мод тарьж, гадна талбайн зүлэгжүүлэлт хийсэн.<br>/Зураг 5/ |
| **Газар доорх усны чанар, хүн амын эрүүл мэнд** | Үнсэн сангийн үнсийг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан, тэдгээрт нийцүүлж байх. | Агаарын чанар | Жил бүр | 7,000,000 | “Улаангом тохижилт үйлчилгээ”ОНТҮГ-тай гэрээ байгуулсан. /Зураг 6/ |

## 2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

| Болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хугацаа | Зардал /төг/ | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Ахуйн болон химийн аюултай хатуу хог хаягдал** | Ахуйн хог хаягдал түр хадгалах сав байгуулах, хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх. | Үйлдвэрийн орчинд | Тухай бүр | - | Ахуйн хог хаягдлыг тухай бүрд нь үнс тээвэрлэх машинаар нэгдсэн хогийн цэг рүү тээвэрлэдэг. |
| | Хатуу хог хаягдлыг ангилан ялгах менежментийг сайжруулах, ажилчдад сургалт зохион байгуулах. | Нийт ажилчдад | 4,10 сард | - | Ажилчдын сургалтаар хамтатган мэдээлэл өгсөн. |
| | Хатуу хог хаягдлыг ангилан ялгах түр цэг байгуулах | - | 11 сард | 1,030,000 | Ахуйн болон дахивар бүтээгдэхүүнийг ялган ангилах 2 хогийн сав хийж байна. |
| **Хог хаягдал хуримтлагдах** | Байгууллагын талбай орчныг бохирдуулахаас сэргийлж, холбогдох байгууллагатай хамтран ойр орчимд тогтмол цэвэрлэгээ хийх. | Ойр орчмын 50 метр газарт | Улирал бүр | - | Байгууллагын хашаан дотор болон орчны 50м талбайд улирал бүр 1-2 удаа тогтмол цэвэрлэгээ хийсэн. /Зураг 7/ |

## 3. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний тайлан

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Зардал /төг/ | Хугацаа | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|
| **Химийн бодисын ашиглалт, хадгалалт** | | | | |
| **ХБ-ын хадгалалт, ашиглалтын явцад асгарах, Хөдөлмөр хамгааллын дүрэм алдагдсанаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх** | Химийн бодисын хадгалах шүүгээ бүрэн бүтэн байлгах, засвар үйлчилгээний зардал | 5,500,000 | - | Лабораторийн сорох шүүгээ худалдан авч, байрлуулсан. /Зураг 8/ |
| | ХБ-той ажиллах ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангах | Нийтээр тусгагдсан | Сар бүрийн эхний өдөр | ХХ-ын нормын дагуу болон гүйцэтгэх ажлын шаардлагын дагуу хувцас, хэрэгсэл олгогддог. /Зураг 9/ |
| | Ажилчдад химийн бодистой харьцаж ажиллах зааварчилгаа, сургалт явуулах | - | Сар бүр | Химийн бодистой харьцан ажиллах үеийн зааварчилгаар тогтмол өгч хэвшсэн. /Зураг 10/ |
| | Ажлын байранд эмийн сангийн баяжуулалт хийх | 100,000 | Улирал бүр | Лабораторит зориулалтын эмийн сан байрлуулан,улирлаар хангалт хийдэг. /Зураг 11/ |
| **Ослын эрсдлээс урьдчилан сэргийлэлт** | | | | |
| **ХБ-ын агуулахын битүүмжлэл алдагдаж, агаар, ус хөрсөөр тархах, ХБ-ын ашиглалтын үед асгарч алдагдах** | ХБ-т өртсөн үед яаралтай тусламж үзүүлэх хэрэгсэл, эмийн сан бий болгож, тодорхой газар байрлуулах | 100,000 | Улирал бүр | Эмийн санд арчиж цэвэрлэх, боож ариутгах хэрэгсэл болон өвчин намдаах зориулалтын эм бэлдмэлээр хангагдсан. /Зураг 11/ |
| **ХБ-ын агуулах болон лабораторит гал гарах** | Лабораторийн өрөөг галын аюулын эсрэг хэрэгслээр хангах /галын хор, элс, хүрз, г.м/ | 100,000 | 8 сард | Галын аюулгүйн байдлын самбар болон галын сараа бүрдүүлэн байрлуулсан. /Зураг 12/ |

## 4. Осол, эрсдлийн төлөвлөгөөний тайлан

| Болзошгүй сөрөг нөлөөллүүд | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хугацаа | Зардал /төг/ | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** |
| **Гэнэтийн болзошгүй осол эрсдэл** | | | | | |
| **Аянга цахилгаан** | ДС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх. | Цахилгаан тоноглолууд | 10 сард | - | СУН-2 тоноглол суурилагдаж газардуулсан. /Зураг 13/ |
| **Нефть болон химийн аюултай бодис асгарах** | Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах | Байгууллагын орчинд | 5 сард | 110,000 | Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдах шатахууныг зөөврийн зориулалтын саваар зөөвөрлөж, тусгай өрөөнд байрлуулсан баканд хадгална. /Зураг 14/ |

## 5. Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулсан ажлын тайлан

| Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хугацаа | Зардал /төг/ | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|
| Бүх ажиллагсдыг мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулах. | Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах | 4 сард | 7,800,00 0 | “Жаргалын үүд” эмнэлэгт урьдчилсан сэргийлэх үзлэгт нийт ажилчдыг хамруулсан. /Зураг 15/ |
| Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сурталчилгааг тогтмол хийж байх, ”Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай ажилчид танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх. | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа | Өдөр бүр, сар бүр, тухай бүр | - | Аюулгүй ажиллагааны сар бүрийн давтан зааварчилгаа, үйлдвэрлэлтэй танилцах шинэ ажилтны урьдчилсан зааварчилгаа, ажлын онцлогоор өгөгддөг тухайлсан зааварчилгааг Хөдөлмөр хамгаалалын инженер өгч, журнал хөтөлдөг./Зураг 16/ |
| Ажилчдад өглөө бүр АА-ы зааварчилгааг өгч гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилтныг аюулгүй ажиллах арга барилд байнга сургах. | Аюулгүй ажиллагаа хариуцагч нар | Өдөр бүр | - | Техникийн ажилчид өглөө бүр аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж гарын үсэг зурж ажилд ордог. /Зураг 17/ |
| Ажлын байрны гэрэлтүүлгийг жигд хүрэлцээтэй тусаж байхаар ерөнхий болон хэсгийн гэрэлтүүлгийг сайжруулах. | Ажлын байрны орчин | Сар бүр | 1,500,00 0 | Станцын хэсэгт 16 байршилд 20ш LED гэрэлтүүлэг, ДДТ-үүдэд 20ш мэдрэгчтэй гэрэлтүүлэг сольж буюу шинэчлэн хийсэн. |
| Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ MNS 5080:2001 стандартыг мөрдөж ажиллах. | Ажлын байрны орчин | 10 сард | 4,500,00 0 | Ажлын байрны дуу чимээ, чийгшил, гэрэлтүүлэг, тоосонцор, температурыг хэмжих багажуудаар хэмжилт хийгдэж байна. /Зураг 18/ |

## 6. Удирдлага –зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний тайлан

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Зардал /төг/ | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх . | - | 7 сард | ХАБ-ын инженер | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлуулах, тайлагнах журам боловсруулан мөрдөн ажиллаж байна. /Зураг 19/ |
| **2** | Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул зэрэг гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага, хүмүүстэй хамтран зохион байгуулах. | 1,000,000 | 4,10 саруудад | ХАБ-ын инженер<br><br>Мэргэжлийн байгууллага | ОБГ-тай хамтарсан галын аюулгүй байдлын онол, практикийн сургалт;<br>ҮО, МШӨ, ХАБЭА-н тухай хууль сэдвүүдээр Политехник коллеж, Нийгмийн даатгалын хөдөлмөрийн байцаагчийн хамтарсан сургалт;<br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны дүрмүүдээр Хөдөлмөрийн аюулгүй байдлын инженер сургалт орсон. /Зураг 20/ |
| **3** | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангах. | 50 сая | 7 сард<br>XXX-ийг сар бүр | Ажил олгогч | Хөдөлмөр хамгааллын зуны хувцсыг жил бүр, хамгаалах хэрэгслийг сар бүр олгодог. /Зураг 21/ |
| **4** | Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалах хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, эмээр хангах. | ХАБЭА-н зардал | Жил бүр<br>Сар бүр,<br>Өдөр бүр | Ажил олгогч | Эмнэлгийн үзлэгт жил бүр бүх ажилчдыг оруулдаг. Үдийн цайны цагаар ажилчдыг хоолоор үйлчилдэг гуанз ажилладаг. Бүх цехүүдэд эмийн сан байрлуулсан. |
| **5** | Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах. | 2,000,000 | 9 сард | Албадууд | Компаний хэмжээний бүх цех нэгжүүдэд галын сараар иж бүрэн бүрдүүлэн байрлуулсан. /Зураг 22/ |
| **6** | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ-д хүргүүлэх. | - | 10 сард | ХАБ-ын инженер | Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайлан гарган хүргүүлсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **7** | Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөр төлөх. | Үйл ажиллагааны зардал | Гэрээний хугацаа | Санхүү алба | Сар бүр ус, цахилгааны төлбөрийн төлөлт хийгддэг. /санхүүгийн баримт/ |
| **8** | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж батлуулах. | - | 2 улиралд | ХАБ-ын инженер | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан БОУАӨЯ-аар батлуулсан. |
| **9** | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах. | - | Жил бүр | ХАБ-ын инженер | Орчны болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тухай бүр цэвэрлүүлэн ачилт хийдэг. |
| **10** | Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ аймгийн ТҮК-тай хийсэн гэрээний дагуу зайлуулах. | 7,000,000 | Жил бүр | | “Улаангом тохижилт үйлчилгээ”ОНТҮГ-тай гэрээ байгуулсан. |
| **11** | Гадаад орчны хэмнэлттэй гэрэлтүүлэг ашиглах. | 1,336,500 | 10 сард | Цахилгааны инженер | Станцын хашаан гэрэлтүүлгийг 9 байршилд ЛЕД гэрлээр сольж нэмэгдүүлсэн. |

## 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөөний тайлан

| БОМТ-ий хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ | Мэдээллийн агуулга | Хугацаа | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|
| Байгаль орчны газар | Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан | 10 сарын 31 | БОМТ-нд 7 бүлэг сэдвээр 38 ажил хийхээр төлөвлөсний тайланг хүргүүлж байна. |
| Бүх шатны Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч | -БОМТ-ний тухайн жилийн тайлан,<br>- Ирэх жилийн төлөвлөгөө | 12-р сарын 1-ний дотор | - |
| Орон нутаг, төрийн бус байгууллагууд, олон нийт | | Жил бүр 1 удаа | |
| Төрийн захиргааны төв байгууллага | | 12-р сарын 10-ны дотор | 2026 оны БОМТ-г хугацаандаа гүйцэтгэж батлуулан ажиллана. |

**Зураг 1. Үнс барих технологийн шинэчлэлт**



## Зураг 2. Агаарын шинжилгээ хийлгэх гэрээ, шинжилгээний хуудас



БАТЛАВ
Увс аймгийн УЦУОШТ-ийн дарга
. . . . /Б.ПҮРЭВСҮРЭН/
20 25 оны 01 р сарын 15 өдөр

БАТЛАВ.
Улаангом 2-р дулааны станц-ТӨХК
дарга түр орлон гүйцэтгэгч
. . . . /П.БАТ-ОРШИХ/
2025 оны 01 р сарын 15 өдөр

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**
**№ 01/2025**

**Нэг. Гэрээний зорилго, үндэслэл**

Байгаль хамгаалах тухай хуулийн 9 – р зүйлийн 1- 3 заалт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6-р зүйлийг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэл үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлж болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлох, түүнийг багасгах, арилгахад үндсэн судалгаа, дүгнэлт хийх зорилгоор орчны /агаар, хөрсний/ бохирдолд хяналт тавих, орчны шинжилгээний ажлыг гүйцэтгэхэд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

**Хоёр. Гэрээний харилцагч талууд**

2.1 Нэг талаас тухайн аж ахуйн нэгж, компани /цаашид захиалагч тал гэх/, нөгөө талаас Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар /цаашид гүйцэтгэгч тал гэх/ зэрэг байгууллагууд нь энэхүү гэрээний харилцагч талууд болж гэрээний биелэлтийг бүрэн хариуцаж хамтран ажиллана.

2.2 Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

**Гурав. Захиалагч талын хүлээх үүрэг**

3.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрт тусгасан агаар, хөрс, усны шинжилгээ судалгааг гэрээний дагуу Байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгэх /агаарын шинжилгээг жилд 2 удаа /03 сар, 10 сард/, хөрсний шинжилгээг жилд 1 удаа хийнэ.

3.2 Захиалагч нь гүйцэтгэгчээс ирүүлсэн орчны шинжилгээний дүн мэдээнд үндэслэн дүгнэлт гаргуулж, цаашид авах арга хэмжээг ажлын төлөвлөгөөндөө тусгаж ажиллана.

3.3 Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын зардлыг шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс хураамжийн тарифаар тооцож, гүйцэтгэгч талд нэхэмжлэлийн дагуу, нэхэмжлэл өгсөн өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан төлнө.

3.4 Хяналт шинжилгээгээр ажиллагсадын томилолт, буудал /байр/, ирж, очих унааны бензин, шатахууны зардлыг захиалагч тал хариуцана.

**Дөрөв. Гүйцэтгэгч талын хүлээх үүрэг**

4.1 Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, холбогдох хууль тогтоомж, заавар дүрэм, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг хэрэгжүүлнэ.

4.2 Захиалагчаас ирүүлсэн захиалгын дагуу тухайн объект дээр очиж, дээж, сорьц авах ажлыг зохион байгуулж, мэргэжлийн ажилтанг томилон ажиллуулна. Дээжийг БОШЛ-Ж-7.4 журмын дагуу авна.

4.3 Тухайн сорьцонд сорилт шинжилгээ гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа MNS, MNS ISO стандарт, аргачлалын дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.



MNAS Accreditation system TL 08-04 MNS ISO/IEC 17025

УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Увс аймаг, Улаангом сум, 5-р баг
Утас: 7045-3680

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

Дугаар он / код № 2025/374
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас : **Улаангом дулааны 2-р станц ТӨХК**
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Ж.Сувд-Эрдэнэ, шинжээч
Сорьцын хэмжээ, төрөл : агаар
Сорьцыг авсан огноо : 2025.04.08
Шинжилгээний аргын стандарт : **MNS,**
Лабораторид ирсэн : 2025.04.08
Шинжилгээ хийсэн огноо : 2025.04.09
Хуудасны тоо : 1/1
Үр дүн:

| Шинжилгээний аргын стандартууд | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж | Хүлцэх агууламж, **MNS 4585:2016** | **Шинжилгээний үр дүн** |
|---|---|---|---|
| MNS 17.2.5.12:2021 | Хүхэрлэг хий – $SO_2$, мг/м$^3$ | 0.450 | 0.008 |
| MNS 17.2.5.11:2021 | Азотын давхар исэл – $NO_2$, мг/м$^3$ | 0.200 | 0.026 |
| MNS 4048:88 | Тоос – нийт, мг/м$^3$ | 0.500 | 0.099 |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч ........ /Ж.СУВД-ЭРДЭНЭ/
(гарын үсэг) (нэр)

Хяналт баталгаажуулсан чанарын менежер ........ /Б.БАЯРАА/
(гарын үсэг) (нэр)

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн сорьцонд хамаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

## Зураг 3. Ус ашиглах гэрээ, үнэ тариф



БАТЛАВ.
"ЧАНДМАНЬ-УВС" ХХК-ИЙН
ЗАХИРЛЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
......................../О.БАТБАЯР/

БАТЛАВ.
УЛААНГОМ ДУЛААНЫ 2 ДУГААР
СТАНЦ ТӨХК-ИЙН
ЗАХИРЛЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
........................................../П.БАТ-ОРШИХ/

**ХҮЙТЭН УСААР ХАНГАХ, БОХИР УС**
**ТАТАН ЗАЙЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2025 оны 01 сарын 01-ний өдөр №49 Улаангом хот

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1. Энэхүү гэрээг хангагч талаас орон сууц нийтийн аж ахуйн "Чандмань-Увс" ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч О.Батбаяр /цаашид "Хангагч" гэх/, хэрэглэгчийг төлөөлж дараах мэдээлэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын бүтээгдэхүүн худалдан авах эрхтэйгээр оролцож байгаа хууль ёсны өмчлөгч болон өмчлөгчөөс албан ёсоор итгэмжлэгдсэн төлөөлөгч ......................... албан тушаалтай ........................................... /цаашид "Хэрэглэгч" гэх/
Хэрэглэгчийн хаяг: 3-р баг
Хэрэглэгчийн нэр: Улаангом дулааны хоёр дугаар станц
Хэрэглэгчийн дугаар: 39003055 Регистрийн дугаар: 4012534
ҮХЭХ гэрчилгээний №: 151200100S /цаашид хамтад нь "Талууд" гэх/ нар Монгол Улсын Иргэний хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Орон сууцны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох эрх зүйн актуудыг үндэслэн 2025 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс 3 /гурав/ жилийн хугацаатай дор дурдсан нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Ус хангамжийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах, хүйтэн усыг зүй зохистой, хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах үүднээс хангагч ба хэрэглэгч нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО**

2.1. Гэрээ байгуулагч хоёр тал Монгол Улсын Иргэний хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох эрх зүйн актуудад заасан эрх үүргийг хэрэгжүүлэхэд гэрээний гол зорилго оршино.

2.2. Энэхүү гэрээ нь хангагчаас хэрэглэгч аж ахуйн нэгжийг хүйтэн усаар хангах, бохир ус татан зайлуулах инженерийн шугам сүлжээг хэвийн найдвартай ажиллуулах, засвар үйлчилгээг шуурхай чанартай хийж гүйцэтгэх.

2.3. Хэрэглэгч хэрэглэсэн усны төлбөр тооцоог тухай бүрд нь барагдуулах зэрэг харилцааг зохицуулахад оршино.

**ГУРАВ. ХАНГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1. Хангагч Монгол Улсын Иргэний хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн

1



1. Хэрэглэгчийн усны төлбөрөө төлөх хэлбэр /сонгох/
   - Банкаар төлж и-баримтаа авна.
   - Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн манай компанийн кассаар
   - Интернет банкаар:
     - Банкны и-биллинг үйлчилгээнд бүртгүүлэн өөрийн орон сууцны нэхэмжлэхээ харж хялбар аргаар төлөх
     - Бусад банкаар төлбөл гүйлгээний утга дээр харилцагчийн дугаар эсвэл байр хаалганы тоотыг бичнэ.
2. Хэрэглэгчийн мэдээлэл авах хаяг /сануулах, түдгэлзүүлэх мэдэгдэл, гэрээ, төлбөртэй холбоотой бусад мэдээлэл/ Хэрэглэгчийн утасны дугаар өөрчлөгдөх бүрд хангагчид мэдэгдэж бүртгүүлэх ба мэдэгдээгүй улмаас үүдэн гарах хохирлыг хангагч хариуцахгүй.
   - Хэрэглэгчийн и-мэйл хаяг: ..........................................................................
   - Хэрэглэгчийн утасны дугаар: ..........................................................................

   /Гэрээнд заасан утас өөрчлөгдсөн тохиолдолд хэрэглэгчийн хүсэлтээр өөрчлүүлж байгаа шинэ дугаарыг зөвхөн хангагчийн дотоод мэдээлэл, солилцооны программд бүртгүүлэх ба гэрээнд өөрчлөлт оруулахгүй байж болно/

**АЖ АХУЙН НЭГЖЭЭС АВАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ**

| № | Үйлчилгээний төрөл | Хэмжих нэгж | Тариф /төгрөг/ | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | | Диаметр | ААН | |
| ЦЭВЭР БОХИР УС | | | | | |
| 1 | Цэвэр ус /Төсөвт/ | төг/$м^3$ | | 7500 | Хот суурины, ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тухайн үеийн батлагдсан үнэ тариф |
| 2 | Бохир ус /Төсөвт/ | төг/$м^3$ | | 7500 | |
| 3 | Цэвэр ус /ААН/ | төг/$м^3$ | | 5000 | |
| 4 | УДДТ-ийн цэвэр ус | төг/$м^3$ | | 2500 | |
| 5 | Бохир ус /ААН/ | төг/$м^3$ | | 7500 | |
| | Бохир /зөөвөр/ | Төг/$м^3$ | | 30000 | |
| 6 | Ус хангамжийн үйлчилгээний суурь хураамж | Цэвэр усны оролтын шугамын диаметр | Ф15<br>Ф20<br>Ф25<br>Ф32<br>Ф40<br>Ф50<br>Ф65<br>Ф80<br>Ф100<br>Ф150<br>Ф150< | 4600<br>6160<br>9400<br>13900<br>20720<br>32080<br>40540<br>54740<br>80880<br>12960<br>0<br>46080<br>0 | |

7

**Зураг 4. Ус ашиглалтын тоолуур**



**Зураг 5. Ногоон байгууламж, зүлэгжүүлэлт**



**Зураг 6.“Улаангом тохижилт үйлчилгээ”ОНТҮГ-тай хийсэн гэрээ**



БАТЛАВ
“УЛААНГОМ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНТҮГ –ЫН
ЗАХИРАЛ З.БАЛЖИННЯМ

**ХОГ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ**

2025 оны 9 -р сарын 06 өдөр №.01 Улаангом

**Нэг: Ерөнхий зүйл**

1.1 Нэг талаас “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ –ыг төлөөлж Хог хаягдал хариуцсан мэргэжилтэн **Өлзий** овогтой **Бэгзсүрэн** нөгөө талаас .................. байгууллагыг төлөөлж .................. овогтой .................. /РД: ........................./ .нар нь Монгол улсын **“Хог хаягдлын тухай хууль” –ийн 10 -р зүйлийн 10.2.3** заалтыг үндэслэн тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**1.2** Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа: **2025 оны 9 сарын 06 –ний өдрөөс 2026 оны 9 сарын 06 –ний өдөр хүртэл**

**Хоёр: Аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг хариуцлага**

2.1 Ажил үйлчилгээ хөнгөн шуурхай болгох үүднээс хуурай хог хаягдал, үнсээ тусгай саванд савлаж тавьсан байх.

2.2 Ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд сард (875,000) төгрөгийг, жилд /(7,000,000)/ - төгрөгөөр саадгүй төлж байх.

2.3 Хог тээвэрлэх машины хуваарьт цагийг алдагдуулж чирэгдэл учруулахгүй байх

**Гурав: “УТҮ” ОНТҮГ -ын хүлээх үүрэг**

3.1 7 хоногт 3-аас доошгүй удаа хог хаягдлыг авах

3.2 Ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд сард (875,000) төгрөг, жилд 7 000000 төгрөгөөр тооцон **Хас банкны 5002836341 (Улаангом тохижилт үйлчилгээ ҮТҮГ** ) тоот дансанд хийх

3.3 Хог ачих хуваарийн дагуу машин техникээ саадгүй ажиллуулах.

**Дөрөв: Бусад зүйл**

4.1 Гэрээнд заасан үүргээ 2 тал сахин биелүүлэх

4.2 Гэрээг биелүүлэхээс татгалзвал хог тээвэрлэх боломжгүй гэж үзэн хуваариас хасах.

4.3 Зөрчлийн улмаас гэрээнд тусгагдсан нөхцөлөөс бусад шалтгаанаар үүссэн хог хаягдлыг буруутай этгээд өөрсдийн зардлаар тээвэрлэх болно.

“Улаангом тохижилт үйлчилгээ”
ОНТҮГ -ыг төлөөлж
..........................
XXXМэргэжилтэн
... ................/ Ө.Бэгзсүрэн /
Утас 7045-4789, Гар утас: 90729092

.................................байгууллага,
ААН –ыг төлөөлж
...................... /................. /
Б РД : ..........................
Утас: .......................... 86460208

**Зураг 7. Орчны цэвэрлэгээ**





**Зураг 8. Лабораторийн сорох шүүгээ**




**Зураг 9. Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл**



**Зураг 10. Зааварчилгаа өгөгдсөн байдал**







**Зураг 11. Лабораторийн эмийн сан**

**Зураг 12. Лабораторийн галын багаж**







**Зураг 13. Сүлжээний усны насосны газардуулга**







**Зураг 14. Шатахуун хадгалалт**





**Зураг 15. Эрүүл мэндийн үзлэг**





**Зураг 16. Хөдөлмөр хамгаалалын зааварчилгааны журнал**












**Зураг 17. Аюулгүй ажиллагааны өдөр тутмын зааварчилгаа өгөгдсөн байдал**






## Зураг 18. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх багаж







## Зураг 19. БОМТ-ий журам



УВС АЙМАГ
"УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 18 өдөр Дугаар А/42 Улаангом

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
боловсруулах, хянан батлуулах,
тайлагнах журам батлах тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал, Байгаль орчинд нөлөөлех байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлуулах, тайлагнах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний баталгаажих нүүр хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн нүүр хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер /П.Бат-Орших/-т даалгасугай.

3. "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлуулах, тайлагнах журам"-ыг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдлын инженер /Ү.Март/-т үүрэг болгосугай.

4. Журам хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг шийдвэрлэж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Сарнай/-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АНХБАЯР



"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 07 дугаар сарын 18 -ны өдрийн А/42 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. "УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ" ТӨХК байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Уг төлөвлөгөө нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалд нийцсэн байна.

1.3. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч "Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК боловсруулж, БОУАӨЯ-аар батлуулах ба аймгийн байгаль орчны алба хяналт тавин ажиллана.

1.4. БОУАӨЯ - ны баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь компанийн үйл ажиллагаанаас байгаль, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

1.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээ, хог хаягдлын менежментийн, химийн бодисын эрсдэлийн менежментийн, осол эрсдэлийн, ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг буруулах, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний, байгаль орчны менежментийн зэрэг төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгана.

1.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

**Зураг 20. Сургалтын зураг**



**Зураг 21. Хөдөлмөр хамгаалалын хувцас**



**Зураг 22. Галын аюулгүйн багаж**






ГАЛЫН БУЛАН
ЭЛС



